

2024 он 3 сар 15 өдөр

Дугаар 24/02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Нэгж эрх эзэмшигчдийн хурал
зарлан хуралдуулах тухай*

Монгол Улсын Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны №275 тоот тогтоолоор батлагдсан "Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам"-ын 9 дүгээр зүйлийн зохицуулалтыг тус тус үндэслэн "Үндэсний Хувьчлалын Сан" Хамтын ХОС-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

"Үндэсний Хувьчлалын Сан" ХОС-ийн Нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид "Хурал" гэх)-ыг 2024 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 хороо, Сүхбаатарын талбай-2, Сентрал тауэр, 17 давхар, Криптос ресторан хаягт хуралдуулсугай.

1. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Нэгж эрх эзэмшигчдийн хурлын дэгийг Хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг Гуравдугаар хавсралтаар, Саналын хуудасны агуулга, загварыг Дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Хуралд оролцох эрхтэй Нэгж эрх эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 4 дүгээр сарын 08-ны өдрөөр тогтоосугай.
3. Хурлын мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо болон Арилжаа эрхлэх байгууллагад 2024 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн дотор хүргүүлсүгэй.
4. Хурал хуралдуулах тухай мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Ард Менежмент ҮЦК ХХК-ийн албан ёсны цахим хаяг <https://ardmanagement.mn/> дамжуулан 2024 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн дотор нийтэд зарласугай. Давтан зарыг 2024 оны 4 дугаар сарын 5-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулсугай.
5. Нэгж эрх эзэмшигчдийн танилцаж болох хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, саналын хуудас, танилцуулга зэрэг бусад холбоотой баримт бичгийг бэлэн болгож 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор үнэт цаасны компаниудад хүргүүлсүгэй.
6. Нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцох боломжгүй нэгж эрх эзэмшигчдийн Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 16:00 цагаар тасалбар болгосугай.

7. Нэгж эрх эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг Ард Applikeйшн болон цаасан хэлбэрээр хослуулан авсугай.
8. Хурлын даргаар “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн ТУЗ-ийн дарга Г.Цогбадрахыг томилсугай.
9. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:
 - Хурал зохион байгуулах комиссын дарга:
 - “Ард Менежмент ҮЦК” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Хандаа;
 - Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
 - “Үндэсний Хувьчлалын Сан” ХОС-ийн менежер Ч.Даваасамбуу;
 - “Үндэсний хувьчлалын сан” Хамтын ХОС-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Х.Саран;
10. Дараах нэр бүхий хүмүүсийг хурлын **Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр** томилсугай. Үүнд:
 - Тооллогын комиссын дарга:
 - Ө. Бямбагэрэл
 - Хуулийн зөвлөх
 - Ард Секюритиз ҮЦК ХХК
 - Тооллогын комиссын гишүүд:
 - Т. Батбаяр
 - Дилер
 - Ард Секюритиз ҮЦК ХХК
 - У. Намуун
 - Хөрөнгө оруулалтын банкны хэлтсийн ахлах
 - Ард Секюритиз ҮЦК ХХК
11. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулж, хурлын зар мэдээг хүргэж, энэхүү тогтоолыг бүрэн дүүрэн, түргэн шуурхай гүйцэтгэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Нэгж эрх эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэсэн шийдвэр болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ч.Хандаад даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.ЦОГБАДРАХ